# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 34 (559)

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай*
- *Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай*
- *Орон нутгийн хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**
**Улаанбаатар хот**
**2008 он**

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2008 оны есдүгээр сарын 14 №34 (559)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 579. | Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай | Дугаар 04 | 986 |
| 580. | Монгол Улсын Их Хурлын дэд дарга нарыг сонгох тухай | Дугаар 05 | 987 |
| 581. | Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 06 | 988 |
| 582. | Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай | Дугаар 07 | 988 |
| 583. | Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай | Дугаар 08 | 988 |
| 584. | Байнгын хорооны гишүүнээр батлах тухай | Дугаар 09 | 989 |
| 585. | Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай | Дугаар 10 | 989 |
| 586. | Орон нутгийн хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай | Дугаар 11 | 989 |
| 587. | Сонгуулийн зардлын хэмжээ батлах тухай | Дугаар 12 | 989 |


### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


| | | | |
|---|---|---|---|
| 588. | Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 248 | 990 |
| 589. | Дамдинжавын Бандид Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай | Дугаар 249 | 991 |
| 590. | Чимэдбазарын Насантогтоход Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай | Дугаар 250 | 991 |
| 591. | Далхсүрэнгийн Төмөрт Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай | Дугаар 251 | 991 |
| 592. | Увшийн Доёдод Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай | Дугаар 252 | 992 |
| 593. | Хүрэлийн Сүхбаатарт Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай | Дугаар 253 | 992 |
| 594. | Пунцагийн Санжидад Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай | Дугаар 254 | 992 |
| 595. | Сандагийн Бямбасүрэнд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай | Дугаар 255 | 992 |
| 596. | Чогсүрэнгийн Дугуйцагаанд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай | Дугаар 256 | 993 |
| 597. | Чултэмийн Цэвэлмаад Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай | Дугаар 257 | 993 |
| 598. | Доржийн Чулуунсүрэнд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай | Дугаар 258 | 993 |
| 599. | Хасын Дагийсүрэнд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай | Дугаар 259 | 993 |
| 600. | Лхагвын Ундралбатад Монгол Улсын гавъяат дасгалжуулагч цол хүртээх тухай | Дугаар 260 | 994 |
| 601. | Халиуны Болдбаатарт Монгол Улсын гавъяат дасгалжуулагч цол хүртээх тухай | Дугаар 261 | 994 |
| 602. | Удо Баркманн, Мартин Бааренберг нарыг "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 262 | 994 |

| | | | |
|---|---|---|---|
| 603. | БНБУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 272 | 994 |
| 604. | Танхимын тэргүүнийг улируулан томилох тухай | Дугаар 273 | 995 |

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 605. | Нэрэмжит болгох тухай | Дугаар 301 | 995 |
| 606. | Соёлын өвийн төвийг өргөжүүлэх тухай | Дугаар 302 | 995 |
| 607. | Хөтөлбөр батлах тухай | Дугаар 303 | 995 |
| 608. | Дүрэм батлах тухай | Дугаар 304 | 1005 |
| 609. | Ажилд томилох тухай | Дугаар 331 | 1008 |
| 610. | Ажилд томилох тухай | Дугаар 332 | 1008 |



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2008 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр** | **Дугаар 04** | **Улаанбаатар хот**

### Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.3 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

***1/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо:***

1. Ринчиннямын Амаржаргал
2. Сүхбаатарын Батболд
3. Яйчилын Батсуурь
4. Гаваагийн Батхүү
5. Лувсанвандангийн Болд
6. Наваансамдангийн Ганбямба
7. Луймэдийн Гансүх
8. Лувсаннямын Гантөмөр
9. Раднаасумбэрэлийн Гончигдорж
10. Доржрамбын Дамба-Очир
11. Халидолдагийн Жекей
12. Энэбишийн Мөнх-Очир
13. Халзхүүгийн Наранхүү
14. Санжаасүрэнгийн Оюун
15. Шинэнсамбуугийн Сайхансамбуу
16. Дамдингийн Хаянхярваа
17. Очирбатын Чулуунбат
18. Миеэгомбын Энхболд
19. Нямаагийн Энхболд

***2/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо:***

1. Хавдисламын Баделхан
2. Догсомжавын Балдан-Очир
3. Батжаргалын Батбаяр
4. Сундуйн Батболд
5. Сүхбаатарын Батболд
6. Яйчилын Батсуурь
7. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
8. Гарьдхүүгийн Баярсайхан
9. Рэнцэнгийн Буд
10. Наваансамдангийн Ганбямба
11. Луймэдийн Гансүх
12. Ламжавын Гүндалай
13. Гомбожавын Занданшатар
14. Даваагийн Кёкүшюзан Батбаяр
15. Халзхүүгийн Наранхүү
16. Цэрэнбатын Сэдванчиг
17. Дэндэвийн Тэрбишдагва
18. Цэгмидийн Цэнгэл
19. Жадамбын Энхбаяр

***3/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо:***

1. Зоригийн Алтай
2. Дашжамцын Арвин
3. Хоохорын Бадамсүрэн
4. Халтмаагийн Баттулга
5. Цэвэлмаагийн Баярсайхан
6. Сандагийн Бямбацогт
7. Цэрэнпилийн Даваасүрэн
8. Цэдэвийн Дашдорж
9. Долгионгийн Дондог
10. Дэлэгийн Загджав
11. Даваагийн Кёкүшюзан Батбаяр
12. Самбуугийн Ламбаа
13. Дуламсүрэнгийн Оюунхорол
14. Алмаликийн Тлейхан
15. Чүлтэмийн Улаан
16. Баттогтохын Чойжилсүрэн
17. Миеэгомбын Энхболд
18. Өлзийсайханы Энхтүвшин

***4/Төрийн байгуулалтын байнгын хороо:***

1. Норовын Алтанхуяг
2. Цогтын Батбаяр
3. Сундуйн Батболд

4. Жамъянсүрэнгийн Батсуурь
5. Эрдэнийн Бат-Үүл
6. Гарьдхүүгийн Баярсайхан
7. Сангажавын Баярцогт
8. Ламжавын Гүндалай
9. Долцонгийн Дондог
10. Дэлэгийн Загджав
11. Самбуугийн Ламбаа
12. Данзангийн Лүндээжанцан
13. Цэндийн Нямдорж
14. Дүрзээгийн Одхүү
15. Давгадоржийн Очирбат
16. Санжаасүрэнгийн Оюун
17. Раднаабазарын Раш
18. Чимэдийн Сайханбилэг
19. Жамъянхорлоогийн Сүхбаатар
20. Нямаагийн Энхболд

***5/Төсвийн байнгын хороо:***

1. Норовын Алтанхуяг
2. Ринчиннямын Амаржаргал
3. Дашжамцын Арвин
4. Хавдисламын Баделхан
5. Нямжавын Батбаяр
6. Цогтын Батбаяр
7. Лувсанвандангийн Болд
8. Лувсаннямын Гантөмөр
9. Даваажавын Ганхуяг
10. Цэрэнпилийн Даваасүрэн
11. Доржданбын Дамба-Очир
12. Дамдины Дэмбэрэл
13. Дашзэвэгийн Зоригт
14. Давгадоржийн Очирбат
15. Шинэнсамбуугийн Сайхансамбуу
16. Цэрэнбатын Сэдванчиг
17. Чүлтэмийн Улаан
18. Дамдингийн Хаянхярваа
19. Чимэдийн Хүрэлбаатар
20. Баттогтохын Чойжилсүрэн
21. Очирбатын Чулуунбат

***6/Хууль зүйн байнгын хороо:***

1. Халтмаагийн Баттулга
2. Эрдэнийн Бат-Үүл
3. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ
4. Санжаагийн Баяр
5. Сангажавын Баярцогт
6. Раднаасүмбэрэлийн Гончигдорж
7. Дамдины Дэмбэрэл
8. Халидолдагийн Жекей
9. Данзангийн Лүндээжанцан
10. Энэбишийн Мөнх-Очир
11. Цэндийн Нямдорж
12. Дуламсүрэнгийн Оюунхорол
13. Чимэдийн Сайханбилэг
14. Жамъянхорлоогийн Сүхбаатар
15. Жадамбын Энхбаяр
16. Зандаахүүгийн Энхболд
17. Өлзийсайханы Энхтүвшин

***7/Эдийн засгийн байнгын хороо:***

1. Зоригийн Алтай
2. Хоохорын Бадамсүрэн
3. Догсомжавын Балдан-Очир
4. Батжаргалын Батбаяр
5. Нямжавын Батбаяр
6. Гаваагийн Батхүү
7. Жамъянсүрэнгийн Батсуурь
8. Цэвэлмаагийн Баярсайхан
9. Рэнцэнгийн Буд
10. Сандагийн Бямбацогт
11. Даваажавын Ганхуяг
12. Цэдэвийн Дашдорж
13. Гомбожавын Занданшатар
14. Дашзэвэгийн Зоригт
15. Дүрзээгийн Одхүү
16. Раднаабазарын Раш
17. Алмаликийн Тлейхан
18. Дэндэвийн Тэрбишдагва
19. Чимэдийн Хүрэлбаатар
20. Цэгмидийн Цэнгэл
21. Зандаахүүгийн Энхболд

2.Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2008 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр** | **Дугаар 05** | **Улаанбаатар хот**

### Монгол Улсын Их Хурлын дэд дарга нарыг сонгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3.2 дахь заалт, санал хураалтын дүн үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын дэд даргаар Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, Улсын Их Хурлын гишүүн Гаваагийн Батхүү нарыг тус тус сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр | Дугаар 06 | Улаанбаатар хот

### Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлэг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Өлзийсайханы Энхтүвшинг Хууль зүйн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Төрийн байгуулалтын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Баттогтохын Чойжилсүрэнг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Хууль зүйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Дорждамбын Дамба-Очирыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Эдийн засгийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн Хүрэлбаатарыг Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Зандаахүүгийн Энхболдыг Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Лувсаннямын Гантөмөрийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

2.Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр | Дугаар 07 | Улаанбаатар хот

### Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.3 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Зандаахүүгийн Энхболд, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Батжаргалын Батбаяр, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Дуламсүрэнгийн Оюунхорол, Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Өлзийсайханы Энхтүвшин, Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн Хүрэлбаатар, Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Халиддолдагийн Жекей, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэвэлмаагийн Баярсайхан нарыг тус тус сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр | Дугаар 08 | Улаанбаатар хот

### Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 24 дүгээр тойрогт 2008 оны 6 дугаар сарын 29-ний өдөр явуулсанээлжит сонгуулийн дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон Цахиагийн Элбэгдоржийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2008 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр** **Дугаар 09** **Улаанбаатар хот**

**Байнгын хорооны гишүүнээр батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Цахиагийн Элбэгдоржийг Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Хууль зүйн байнгын хорооны гишүүнээр батлалсугай.

2.Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2008 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр** **Дугаар 10** **Улаанбаатар хот**

**Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.4 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхий сайдаар Санжаагийн Баярыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2008 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр** **Дугаар 11** **Улаанбаатар хот**

**Орон нутгийн Хурлын ээлжит сонгууль товлон зарлах тухай**

Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийг 2008 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн ням гаригт явуулахаар 2008 оны 9 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн товлон зарласугай.

2.Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2008 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр** **Дугаар 12** **Улаанбаатар хот**

**Сонгуулийн зардлын хэмжээ батлах тухай**

Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн Хурлын 2008 оны ээлжит сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 415,022,440 төгрөгөөр тогтоосугай.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан зардлыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2008 оны 9 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 08 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 248 | Улаанбаатар хот

**Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай**

Боловсролын салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1. Дэедийн Пүрэв - Нийслэл дэх "Шунхлай сургалт" ХХК-ийн жолооны сургуулийн захирал

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Сүрэнхорлоогийн Андрей - ХААИС-ийн Мал эмнэлэг, биотехнологийн сургуулийн Морфологи-физиологийн тэнхимийн багш, профессор
2. Жавсанжавын Аюурзана - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны иргэн, ахмад багш
3. Нямхүүгийн Баасанцэрэн - Нийслэлийн Налайх дүүргийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга, ахмад багш
4. Идэшийн Баатар - Ховд аймгийн Жаргалант сумын 1 дүгээр дунд сургуулийн математикийн багш
5. Егнэнгийн Бавуудорж - Ховд аймгийн Манхан сумын дунд сургуулийн зөвлөх багш
6. Жунтааны Бадамраа - Ховд аймгийн Булган сумын дунд сургуулийн ахмад багш
7. Бямбын Батаа - Дархан-Уул аймгийн Дархан сумын 19 дүгээр дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
8. Самдангийн Батсуурь - Нийслэлийн Техник, технологийн коллежийн Сургалтын төвийн ахлах мастер
9. Бямбын Батсүрэн - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн албан бус боловсролын "Гэгээрэл хөгжил" төвийн захирал
10. Намсрайн Баттөмөр - Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 2 дугаар дунд сургуулийн хими биологийн багш
11. Намсрайн Бямбаа - Төв аймгийн Зуунмод сумын "Хүмүүн" цогцолбор сургуулийн сургалтын менежер
12. Ядамжавын Гэлэнхүү - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр дунд сургуулийн технологийн багш
13. Цэдэннямын Дашдорж - ШУТИС-ийн Барилгын инженер, архитектурын сургуулийн багш, дэд профессор
14. Хадхүүгийн Жаргалсайхан - ШУТИС-ийн харъяа Уул уурхайн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
15. Ишжамцын Лхам - ХААИС-ийн Нийгмийн ухааны тэнхмийн эрхлэгч
16. Ламжавын Отгон - Орхон аймгийн "Наран" цогцолбор сургуулийн ахмад багш
17. Жадамбаагийн Оюунцэцэг - ХААИС-ийн Биотехнологи, үржүүлгийн тэнхмийн ажилтан
18. Чогсомжавын Сарантуяа - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 5 дугаар дунд сургуулийн бага ангийн багш
19. Эрхэм-Очирын Тамир - МУБИС-ийн философийн багш, доктор, дэд профессор
20. Гомбожавын Тунгалаг - Ховд аймгийн Жаргалант сумын 1 дүгээр дунд сургуулийн бага ангийн багш
21. Оонойн Цэвэлмаа - Нийслэлийн Баянгол дүүргийн 40 дүгээр дунд сургуулийн биологийн багш
22. Мөнхийн Шатархүү - Завхан аймгийн Завханмандал сумын дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
23. Лувсан-Ендонгийн Эрдэнэтуяа - Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн докторантур, магистрантурын салбарын эрхлэгч

**ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Моононгийн Адъясүрэн - Нийслэлийн Баянгол дүүргийн 120 дугаар цэцэрлэгийн нярав
2. Аваанийн Баасанхүү - Монгол-Солонгосын техникийн коллежийн сүлжмэлийн дадлагын багш
3. Дамдингийн Балтсүх - Ховд аймгийн Манхан сумын дунд сургуулийн бага ангийн багш
4. Сүрэнгийн Бүрнээ - Ховд аймгийн Мөнххайрхан сумын дунд сургуулийн багш
5. Хамсангийн Дашцэрэн - ЭМШУИС-ийн Сувилахуйн сургуулийн нүүр ам, согог заслын сувилахуйн багш
6. Чүлтэмийн Дуламжав - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 23 дугаар дунд сургуулийн түүхийн багш
7. Алтангэрэлийн Наранцэцэг - Ховд аймгийн Жаргалант сумын 1 дүгээр дунд сургуулийн технологийн багш
8. Пүрэвсүрэнгийн Нямсүрэн - УБТЗ-ын дээд сургуулийн сургалт-эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал
9. Минжээгийн Очбаатар - Дархан-Уул аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн

төвийн инженер багш

10. Цэрэн-Янживын Оюунчимэг - Төв аймгийн Алтанбулаг сумын дунд сургуулийн сургалтын менежер

11. Бат-Очирын Роза - Ховд аймгийн Жаргалант сумын 1 дүгээр дунд сургуулийн бага ангийн багш

12. Бадамдоржийн Сарантуяа - УБТЗ-ын дээд сургуулийн ерөнхий нягтлан бодогч

13. Хажидын Хүрэлтогоо - ХААИС-ийн Байгалийн ухааны сургуулийн Химийн тэнхимийн багш, доктор, дэд профессор

14. Шагдарсүрэнгийн Цэвээндорж - ШУТИС-ийн Барилгын инженер, архитектурын сургуулийн багш, дэд профессор

15. Цоодолын Цэндсүрэн - ЭМШУИС-ийн Сувилахуйн сургуулийн дотор өвчний сувилахуйн багш

16. Чойполын Цэндхүү - ЭМШУИС-ийн Анагаахын сургуулийн Эм судлалын тэнхимийн туслах ажилтан

17. Дашравдангийн Чимэд - ЭМШУИС-ийн Сувилахуйн сургуулийн халдварт өвчний сувилахуйн багш

18. Сэндэнгийн Энхбаяр - Төв аймгийн Зуунмод сумын "Бүжинхэн" цогцолбор цэцэрлэгийн нярав

**ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Наваані Гантулга - Цагдаагийн академийн Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн тэргүүн дэд захирал

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 28-ны өдөр** | **Дугаар 249** | **Улаанбаатар хот**

### Дамдинжавын Бандид Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай

Биеийн тамир, спортын салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, боксын спортын зэрэг, цолтой тамирчид олныг сургаж бэлтгэн, дасгалжуулсан баг, тамирчдаа тив, дэлхий, олимпийн наадмын тэмцээнүүдэд тогтмол амжилттай оролцуулж, боксын спортыг хөгжүүлэхэд оруулсан онцгой хувь нэмрийг нь үнэлж Монгол Улсын боксын үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагч Дамдинжавын Бандид Монгол Улсын ардын багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 28-ны өдөр** | **Дугаар 250** | **Улаанбаатар хот**

### Чимэдбазарын Насантогтоход Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай

Биеийн тамир, спортын салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, жү-до бөхийн зэрэг, цолтой тамирчид олныг сургаж бэлтгэн, дасгалжуулсан баг, тамирчдаа тив, дэлхий, олимпийн наадмын тэмцээнүүдэд удаа дараа амжилттай оролцуулж, манай оронд жү-до бөхийг хөгжүүлэхэд оруулсан онцгой хувь нэмрийг нь үнэлж Монгол Улсын жү-до бөхийн үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагч Чимэдбазарын Насантогтоход Монгол Улсын ардын багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 28-ны өдөр** | **Дугаар 251** | **Улаанбаатар хот**

### Далхсүрэнгийн Төмөрт Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан сургалт, судалгаа, заах арга зүйн ном, бүтээлүүд туурвиж, монгол хэл бичгийн сургалтанд шинэ аргуудыг нэвтрүүлэн заах арга барилыг сайжруулах, багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх, үндэсний хэл бичгийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, өсвөр үеийг сурган хүмүүжүүлэхэд оруулсан бодитой хувь нэмрийг нь үнэлж Монгол-Энэтхэгийн хамтарсан дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш Далхсүрэнгийн Төмөрт Монгол Улсын ардын багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 252** **Улаанбаатар хот**

**Увшийн Доёдод Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай**

Дээд боловсролын салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллан ЕБС-ийн математик болон бусад хичээлийн сургалтын агуулга, арга зүй, технологийг шинэчлэн хөгжүүлж, шинэ сурах бичиг, гарын авлага бүтээх, багш, удирдах ажилтны мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, боловсролын салбарыг орчин үеийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, үндэсний дээд боловсролтой боловсон хүчин, математикийн багш нарыг сургаж бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж МУИС-ийн Математик компьютерын сургуулийн багш Увшийн Доёдод Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 253** **Улаанбаатар хот**

**Хүрэлийн Сүхбаатарт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай**

Дээд боловсролын салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллан эрчим хүчний тулгамдсан асуудлаар сургалт, эрдэм шинжилгээний олон арван ном, бүтээл туурвиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, манай улсад дээд боловсролтой инженер техникийн ажилтан, үндэсний боловсон хүчин сургаж бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж ШУТИС-ийн Эрчим хүчний инженерийн сургуулийн багш, доктор, профессор Хүрэлийн Сүхбаатарт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 254** **Улаанбаатар хот**

**Пунцагийн Санжидад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай**

Боловсролын салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллан хөдөө аж ахуйн эдийн засаг, менежментийн чиглэлээр олон ном, сурах бичиг, бүтээл туурвиж, хөдөө аж ахуйн мэргэжилтэй боловсон хүчин, эрдэмтдийг бэлтгэх, багшлах боловсон хүчнийг чадваржуулах, сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн зөвлөх багш, профессор Пунцагийн Санжидад Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 255** **Улаанбаатар хот**

**Сандагийн Бямбасүрэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай**

Эрүүл мэнд, боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан сургалт, эрдэм шинжилгээний бүтээлүүд туурвиж, хүн амын дундах сэтгэцийн эмгэгүүдийн эмнэлзүйн бүтэц, онцлогийг тодорхойлох, мансуурал судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх, анагаах ухааны нарийн мэргэжлийн боловсон хүчин, эрдэмтдийг сургаж бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж ЭМШУИС-ийн Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор Сандагийн Бямбасүрэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 08 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 256 | Улаанбаатар хот

**Чогсүрэнгийн Дугуйцагаанд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай**

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан багшлах боловсон хүчин бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох, багш нарын мэргэжил, ур чадвар, бага ангийн сургалтын чанарыг дээшлүүлэх, сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэх, өсвөр үеийг сурган хүмүүжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж МУБИС-ийн Багшийн сургуулийн багш Чогсүрэнгийн Дугуйцагаанд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 08 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 257 | Улаанбаатар хот

**Чүлтэмийн Цэвэлмаад Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай**

Боловсролын байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, багш нарын мэдлэг чадвар, заах ур чадварыг дээшлүүлэн чадварлаг хамт олныг бүрдүүлж, сургалтын арга барилыг боловсронгуй болгох, боловсролын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн Баянгол дүүргийн "Эрдмийн ундраа" цогцолбор сургуулийн дэд захирал Чүлтэмийн Цэвэлмаад Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 08 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 258 | Улаанбаатар хот

**Доржийн Чулуунсүрэнд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай**

Орон нутгийн боловсролын байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэн багш сурагчдын ажиллаж суралцах таатай орчинг бүрдүүлж, сургалтын арга барилыг боловсронгуй болгох, залуу багш нарыг сургаж дадлагажуулахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж Төв аймгийн Зуунмод сумын 4 дүгээр дунд сургуулийн захирал Доржийн Чулуунсүрэнд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 08 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 259 | Улаанбаатар хот

**Хасын Дагийнсүрэнд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай**

Боловсролын байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, цэцэрлэгийн материаллаг баазыг бэхжүүлэн хүүхэд багачуудын сурч хүмүүжих таатай орчинг бүрдүүлж, тэдний авъяас чадварыг хөгжүүлэн сургуулийн өмнөх боловсролыг олгоход оруулсан хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн Хан-Уул дүүргийн 28 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Хасын Дагийнсүрэнд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 260** **Улаанбаатар хот**

**Лхагвын Ундралбатад Монгол Улсын гавъяат дасгалжуулагч цол хүртээх тухай**

Буудлагын спортын дасгалжуулагчаар олон жил үр бүтээлтэй ажиллаж, спортын зэрэг, цолтой тамирчид бэлтгэх, дасгалжуулсан баг, тамирчид нь тив, дэлхий, олимпийн наадмын тэмцээнүүдэд удаа дараа спортын өндөр амжилт үзүүлснийг тэмдэглэж, манай оронд буудлагын спортыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Монгол Улсын буудлагын үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагч Лхагвын Ундралбатад Монгол Улсын гавъяат дасгалжуулагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 261** **Улаанбаатар хот**

**Халиуны Болдбаатарт Монгол Улсын гавъяат дасгалжуулагч цол хүртээх тухай**

Жү-до бөхийн дасгалжуулагчаар үр бүтээлтэй ажиллан дасгалжуулсан баг, тамирчид нь тив, дэлхий, олимпийн наадмын тэмцээнүүдэд удаа дараа оролцож спортын өндөр амжилт үзүүлснийг тэмдэглэж, манай оронд жү-до бөхийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Монгол Улсын жү-до бөхийн үндэсний шигшээ багийн дасгалжуулагч Халиуны Болдбаатарт Монгол Улсын гавъяат дасгалжуулагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 08 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 262** **Улаанбаатар хот**

**Удо Баркманн, Мартин Бааренберг нарыг "Найрамдал" медалиар шагнах тухай**

Монгол Улс, ХБНГУ-ын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, манай улсад герман хэл, соёлын сургалтыг дэмжих болон монгол судлалд оруулсан хувь нэмрийг нь үнэлж МУИС-ийн зочин, профессор, монголч эрдэмтэн Удо Баркманн, Монгол-Германы 38 дугаар дунд сургуулийн мэргэжилтэн багш Мартин Бааренберг нарыг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр** **Дугаар 272** **Улаанбаатар хот**

**БНБУ-ын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай**

Монгол Улс, БНБУ-ын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж БНБУ-ын иргэн дараахь хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Никола Николов - "Болгар дахь Монголын анд нөхөд" нийгэмлэгийн дарга, зохиолч, сэтгүүлч

**"НАЙРАМДАЛ" МЕДАЛИАР:**

2. Лычезар Стефанов - БНБУ-ын Сангийн яамны Гадаад санхүүгийн газрын захирал
3. Красимир Стефанов - БНБУ-ын Гадаад хэргийн яамны Ази, Австрали, далайн орнуудын газрын захирал
4. Ненко Маринов - Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн талаар хамтран ажиллах Болгар-Монголын Засгийн газар хоорондын комиссын Болгарын хэсгийн нарийн бичгийн дарга

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2008 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр** **Дугаар 273** **Улаанбаатар хот**

**Танхимын тэргүүнийг улируулан томилох тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.6, 32.7 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Цэндийн Амарсайханыг Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүнээр улируулан томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 07 дугаар сарын 29-ний өдөр** **Дугаар 301** **Улаанбаатар хот**

**Нэрэмжит болгох тухай**

Холбогдох байгууллагын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Сүхбаатар аймгийн Асгат сумын бүрэн дунд сургуулийг нэрт эрдэмтэн Гүнжийн Сүхбаатарын нэрэмжит болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД Н.БОЛОРМАА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 07 дугаар сарын 29-ний өдөр** **Дугаар 302** **Улаанбаатар хот**

**Соёлын өвийн төвийг өргөжүүлэх тухай**

Засгийн газрын тухай хуулийн 9.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9.6, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Утга соёлын үндэсний төв" төрийн бус байгууллагын Удирдах зөвлөлөөс гаргасан санал, хүсэлтийн дагуу НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-аас хэрэгжүүлсэн төслийн үр дүнд бий болсон эд хөрөнгийг Соёлын өвийн төвд зохих журмын дагуу шилжүүлэн авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаад даалгасугай.

2. Соёлын өвийн төвд утга соёлын өвийг хадгалж хамгаалах чиг үүрэг нэмэгдэж байгаатай холбогдуулан шаардагдах зардлын эх үүсвэрийг Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД Н.БОЛОРМАА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 07 дугаар сарын 29-ний өдөр** **Дугаар 303** **Улаанбаатар хот**

**Хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор батлсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт жил бүр тусгах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татан оролцуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Улаан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Цолмон, нийслэлийн Засаг

дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Т.Билэгт нарт үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг бусад төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан зохион байгуулж, хөтөлбөрийн хүрээнд баригдах орон сууцны хорооллын газрын асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Цолмон, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Т.Билэгт нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД Ц.ЦОЛМОН**

**Засгийн газрын 2008 оны 303 дугаар тогтоолын хавсралт**

## УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛ БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Нийслэлийн хэмжээнд нийт 215.7 мянган айл өрх байгаагаас 41.4 хувь буюу 89.2 мянга нь орон сууцанд, 58.6 хувь буюу 126.5 мянга нь гэр хороололд амьдарч байна. Жилд дунджаар 30.0 мянга гаруй хүн нийслэлд шилжин ирж байгаагийн ихэнх нь гэр хороололд суурьшиж байгаа бөгөөд Улаанбаатар хотын гэр хороолол 1990-ээд оны үед 6.5 мянган га талбайг эзэлж байсан бол одоо 14.0 мянган га болон тэлж 2.2 дахин өссөн байна. 2007 оны байдлаар гэр хорооллын айл өрхийн 89 хувь нь газраа өмчилж авсан байна.

Гэр хорооллын нэг өрх жилд дунджаар 5 тонн нүүрс, 4.7 $м^3$ мод түлж байгаа нь хотын агаарыг бохирдуулах, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх гол эх үүсвэр болж байна.

Гэр хорооллын зуухнаас гарсан дутуу шаталттай нүүрсний утаа, тоосжилт хүйтний улиралд гамшгийн хэмжээнд хүртлээ өсч, бохир ус, хог хаягдал нь агаар, хөрс, ургамал, гадаргын болон гүний усыг байнга бохирдуулж амьсгалын замын болон халдварт өвчин ихсэн хот, суурины ландшафт доройтсон нь гэр хороолол энэ чигээрээ өсөн тэлэх боломжгүй болж байгааг харуулж байна.

Иймээс Улаанбаатар хотод орон сууцны хэрэгцээ их байгааг харгалзан амьдрах орчны нөхцөл муу, барилгажилт болон хүн амын нягтрал багатай, маш их хэмжээний зай талбай эзэлсэн гэр хорооллыг дахин төлөвлөж орон сууц, хүн амын нягтрал сайтай инженерийн болон нийгмийн дэд бүтцийн бүрэн хангамжтай тохилог орон сууцны хороолол болгон хөгжүүлэх зайлшгүй шаардлага бий болж байна.

Улаанбаатар хотын агаар, хөрс, усны бохирдлыг арилгах хамгийн оновчтой шийдэл нь гэр хорооллыг тухайн газар нутаг дээр нь амьдарч байгаа оршин суугчид, олон нийтийн оролцоотой дахин төлөвлөж инженерийн хангамжтай орон сууцны хороолол болгон хөгжүүлэх явдал юм.

### Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хамрах хүрээ, хэрэгжүүлэх үе шат

2.1. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь олон нийтийн оролцоотойгоор гэр хорооллыг дахин төлөвлөж орон сууцны хороолол болгон хөгжүүлж Улаанбаатар хотын агаар, хөрс, усны бохирдлыг арилган орон сууц, түүний дэд бүтцийн хэмжээг нэмэгдүүлж, чанарыг сайжруулан иргэдийг эрүүл ахуй, аюулгүйн шаардлага хангасан тохилог орон сууцаар хангах явдал юм.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг тодорхойлж байна:

2.2.1. Зорилт 1: хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

2.2.2. Зорилт 2: хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын зураг төсөл боловсруулах;

2.2.3. Зорилт 3: газар, үл хөдлөх хөрөнгө, өмчийн харилцааг зохицуулах;

2.2.4. Зорилт 4: инженерийн дэд бүтцийг байгуулах;

2.2.5. Зорилт 5: орон сууц барих;

2.2.6. Зорилт 6: нийгмийн дэд бүтцийг байгуулах;

2.2.7. Зорилт 7: ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн байгуулах.

2.3. Хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын 6 дүүргийн 22 гэр хорооллыг хамруулан дахин төлөвлөж орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ.

2.3.1. Баянгол дүүрэг (2 гэр хороолол): YII бичил хороолол, Гандан;

2.3.2. Баянзүрх дүүрэг (7 гэр хороолол): XIV хороолол, Зүүнсэлбэ, Дарь-Эх, Улаанхуаран, Шархад, Амгалан, Улиастай;

2.3.3. Сонгинохайрхан дүүрэг (4 гэр хороолол): Өнөр-II, Толгойт, Орбит, Ханын материал;

2.3.4. Сүхбаатар дүүрэг (3 гэр хороолол): VII хороолол, 32-ын тойрог орчмын хороолол, 3-7 буудлын хороолол;

2.3.5. Хан-Уул дүүрэг (2 гэр хороолол): Яармаг, Нисэх;

2.3.6. Чингэлтэй дүүрэг (4 гэр хороолол): Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз орчмын хороолол, Дэнжийн 1000, Хайлааст, Чингэлтэй орчмын замын дагуухи хороолол.

2.4. Хөтөлбөрийн зорилтуудыг дараахь 3 үндсэн чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ:

2.4.1. Үндсэн чиглэл 1. Төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбон нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ. (Хотын төвийн хэсгийн гэр хороолол хамрагдана. Инженерийн болон нийгмийн дэд бүтцийн иж бүрэн хангамжтай, худалдаа, үйлчилгээний төв бүхий өндөр нягтралтай нийтийн орон сууцны хороолол байна);

2.4.2. Үндсэн чиглэл 2. Төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбон нийтийн болон амины орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ (Төвийн болон төвийн хэсэгтэй залгаа гэр хороолол хамрагдана);

2.4.3. Үндсэн чиглэл 3. Бие даасан инженерийн шугам сүлжээнд холбон амины орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ (Хотын дунд хэсгийн болон захын гэр хороолол хамрагдана. Амьдрах таатай орчин бүхий амины орон сууцны хороолол байна).

2.5. Хөтөлбөрийг дараахь 3 үе шатаар хэрэгжүүлнэ:

2.5.1. нэгдүгээр үе шат (2008-2011 он): Орон сууцны хороолол болгон хөгжүүлэх гэр хорооллын байршил, хүчин чадлыг тодорхойлж, инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хангамжийн хэрэглээг тооцон, шаардлагатай хөрөнгө оруулалтыг төвлөрүүлж, эхний ээлжийн хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж орон сууц барьж эхэлнэ;

2.5.2. хоёрдугаар үе шат (2012-2015 он): Хотын төвийн гэр хорооллыг инженерийн болон нийгмийн дэд бүтцийн иж бүрэн хангамжтай, өндөр нягтрал бүхий нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлэх барилгажилтын ажил эрчимтэй явагдана;

2.5.3. гуравдугаар үе шат (2016-2020 он): Хотын дунд хэсгийн гэр хорооллыг инженерийн болон нийгмийн дэд бүтцийн иж бүрэн хангамжтай орчин үеийн орон сууцны хороолол, хотын захын гэр хорооллыг орон сууцны анхан шатны дэд бүтэц бүхий амины орон сууцны хороолол болгон хөгжүүлэх барилгажилтын ажил эрчимтэй явагдана.

**Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ**

3.1. Хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтын хүрээнд дараахь чиглэлээр холбогдох хуулийн төсөл боловсруулах:

3.1.1. хотыг дахин хөгжүүлэх чиглэлээр;

3.1.2. үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний талаар;

3.1.3. дэд бүтцийн төслийг санхүүжүүлэх, барих, ашиглах, засвар арчлалт хийх, шилжүүлэх талаар;

3.1.4. үл хөдлөх хөрөнгийн барьцаагаар баталгаажсан үнэт цаасны талаар;

3.1.5. үнэт цаасжуулах болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны талаар.

3.2. Дараахь хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах:

3.2.1. Газрын тухай хууль;

3.2.2. Орон сууцны тухай хууль.

3.3. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл болон эзэмшилд байгаа газрыг орон сууцаар солих, худалдан авах, газрын зориулалтыг өөрчлөхтэй холбогдсон эрх зүйн баримт бичгийг боловсруулж батлан хэрэгжүүлэх.

3.4. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын зураг төсөл боловсруулах зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.4.1. хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын зураг төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулах (1 дүгээр хүснэгтэд заасан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулсан болно. 2 дугаар хүснэгтэд заасан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах болно).

3.4.2. Монгол орны нөхцөлд орон сууцны хорооллыг экологид ээлтэй төлөвлөх, байгаль ландшафтыг барилгажилттай зөв хослуулан хөгжүүлэх аргачлалыг боловсруулах.

Хүснэгт 1

| № | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө | Баталсан шийдвэр | Зураг төслийн байгууллага |
|---|---|---|---|
| Үндсэн чиглэл 1. Төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбон нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлэх чиглэлээр | | | |
| 1 | XIV хороолол<br>(БЗД 13,14-р хороо, Зүүн дөрвөн замаас Амгалангийн тойрог, Энхтайваны өргөн чөлөө Нарны замын хооронд) | нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 84 дүгээр тогтоол | "Хот байгуулалтын хөгжлийг дэмжих төв" ТББ |
| 2 | VII хороолол<br>(СБД.9,10,11-р хороо, Их тойруу 32-ын тойрог хооронд) | - | "Бадмаараг" ХХК |
| 3 | МҮОНРТ орчмын хороолол<br>(ЧД 7,8-р хороо, МҮОНРТ-ийн зүүн талд) | нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 267 дугаар тогтоол | "Говь травел" ХХК |
| 4 | Зүүнсэлбэ хороолол<br>(БЗД 13-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, Нарны замын хооронд) | нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 154 дүгээр тогтоол | нийслэлийн хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэн |
| Үндсэн чиглэл 2. Төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбон нийтийн болон амины орон сууцны хороолол болгон хөгжүүлэх чиглэлээр | | | |
| 1 | Гандан хороолол<br>(БГД 16,17-р хороо, Өндөргэгээн Занабазарын гудамж, Гандантэгчилэн хийд орчим) | нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 154 дүгээр тогтоол | нийслэлийн хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэн |
| Үндсэн чиглэл 3. Бие даасан инженерийн шугам сүлжээнд холбон амины орон сууцны хороолол болгон хөгжүүлэх чиглэлээр | | | |
| 1 | Дамбадаржаалин хийд орчмын амины орон сууцны бичил хороолол<br>(СБД 15-р хороо, Дамбадаржаалин хийд орчим) 52 айл | БХБЯ, "Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах төслийн баг" | |
| 2 | Баянхошууны амины орон сууцны бичил хороолол (СХД 10-р хороо) 120 айл | | |

Хүснэгт 2

| № | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө | Дүүрэг | Боловсруулах хугацаа |
|---|---|---|---|
| Үндсэн чиглэл 1. Төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбон нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлэх чиглэлээр | | | |
| 1 | Амгалан орчмын хороолол | Баянзүрх | 2008 |
| 2 | Улиастай орчмын хороолол | Баянзүрх | |
| 3 | VII бичил хороолол | Баянгол | |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Өнөр-II хороолол | Сонгинохайрхан | |
| 5 | 32-ын тойрог орчмын хороолол | Сүхбаатар | |
| 6 | 3-7 буудал орчмын хороолол | Сүхбаатар<br>Чингэлтэй | |
| 7 | Дэнжийн 1000 хороолол | Чингэлтэй | |
| 8 | Шархад орчмын хороолол | Баянзүрх | 2009 |
| 9 | Толгойт орчмын хороолол | Сонгинохайрхан | |
| 10 | Орбит орчмын хороолол | Сонгинохайрхан | |
| 11 | Ханын материал орчмын хороолол | Сонгинохайрхан | |
| 12 | Яармаг орчмын хороолол | Хан-Уул | 2010 |
| Үндсэн чиглэл 2. Төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбон нийтийн болон амины орон сууцны хороолол болгон хөгжүүлэх чиглэлээр | | | |
| 1 | Дарь-Эх орчмын хороолол | Баянзүрх | 2008 |
| 2 | Улаанхуаран орчмын хороолол | Баянзүрх | 2009 |
| 3 | Хайлааст орчмын хороолол | Чингэлтэй | 2010 |
| Үндсэн чиглэл 3. Бие даасан инженерийн шугам сүлжээнд холбон амины орон сууцны хороолол болгон хөгжүүлэх чиглэлээр | | | |
| 1 | Дамбадаржаалин хийд орчмын хороолол | Сүхбаатар | 2008 |
| 2 | Нисэх орчмын хороолол | Хан-Уул | 2009 |
| 3 | Чингэлтэй орчмын хороолол | Чингэлтэй | 2010 |

3.5. Газар, үл хөдлөх хөрөнгө, өмчийн харилцааг зохицуулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.5.1. хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хэрэгжих хил хязгаарт байршиж байгаа иргэд, аж ахуйн нэгжийн судалгааг газар өмчлөл, эзэмшил, ашиглалтын хэлбэрээр нарийвчлан гаргах;

3.5.2. хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хэрэгжих хил хязгаарт газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар чөлөөлөх мэдэгдэл өгөх;

3.5.3. газар чөлөөлөх иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай зөвшилцөн гэрээ байгуулах;

3.5.4. газрын асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэдийн үүсгэл санаачилгын байгууллагыг байгуулах, иргэдийн санаачилгыг дэмжин өрнүүлэх, оролцоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

3.5.5. иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээний дагуу газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.5.6. чөлөөлөгдсөн газрыг цэвэрлэн, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, халдваргүйжүүлэлт хийж барилгажих талбайг бэлэн болгох;

3.5.7. чөлөөлөгдсөн газарт барилга байгууламж барих газрын эрхийг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах зарчмаар дахин хуваарилалт хийх;

3.5.8. чөлөөлөгдөх газрын үнэ, тухайн газар дээрх үл хөдлөх хөрөнгийн үнэ, өмчлөгчөөс уг газарт зарцуулсан хөрөнгийн үнэлгээ тогтоож, газар чөлөөлөхөд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлүүлэх.

3.6. Инженерийн дэд бүтцийг байгуулах зорилтыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

3.6.1. инженерийн хангамжийн гол шугам сүлжээг барих ажлыг төр хариуцаж, хөрөнгө оруулалтын асуудлыг нь үе шаттайгаар шийдвэрлэн орон сууц болон бусад барилга байгууламж барих нөхцөлийг бүрдүүлэх;

3.6.2. хороолол доторхи салбар шугам сүлжээг төсөл хэрэгжүүлэгч байгууллага өөрийн хөрөнгөөр барих;

3.6.3. инженерийн хангамжийн бие даасан эх үүсвэр, шугам сүлжээнд холбох орчин үеийн дэвшилтэт технологийг өөрийн оронд нутагшуулах.

3.7. Инженерийн дэд бүтцийг байгуулах зорилтыг дараахь 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

3.7.1. нэгдүгээр үе шат (2008-2011 он)

-Баянзүрх дүүргийн 13,14-р хорооны нутаг дэвсгэрт орших орон сууцны XIV хороолол, Чингэлтэй дүүргийн 7,8,9-р хорооны нутаг дэвсгэрт орших Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз орчмын хороолол, Сүхбаатар дүүргийн 9,10,11,12-р хорооны нутаг дэвсгэрт орших орон сууцны VII хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

-Инженерийн хангамжийн шугам сүлжээг хорооллын батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.

Инженерийн хангамжийн гол шугам сүлжээнд зарцуулах хөрөнгө оруулалтын урьдчилсан тойм тооцоо

| № | Хороолол | Орон сууцны тоо | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) |
|---|---|---|---|
| 1 | XIV хороолол | 12000 | 20.3 |
| 2 | VII хороолол | 10000 | 14.9 |
| 3 | МҮОНРТ орчмын хороолол | 2500 | 7.4 |
| | Нийт дүн | 24500 | 42.6 |

Инженерийн хангамжийн эх үүсвэрийн хөрөнгө оруулалтын урьдчилсан тойм тооцоо

| № | Эх үүсвэр | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) |
|---|---|---|
| 1 | ТЭЦ-4–ийн уур усны дулааны дэд станц барих | 19.0 |
| 2 | Дулаан, цахилгаан хослон үйлдвэрлэгч 5 дахь эх үүсвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх (ТЭЦ-5) | 120.0 |
| 3 | Улаанбаатар хотын 220, 110кВ-ын цахилгаан дамжуулах их тойрог шугам, дэд станцуудыг барьж өргөтгөх | 90.0 |
| 4 | Цэвэр усны шинэ эх үүсвэрийн судалгаа хийж, техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх | 48.0 |
| 5 | Бохир усны 25 дугаар коллекторыг барьж дуусгах | 3.2 |
| | Нийт дүн | 280.2 |

Авто тээврийн болон явган хүний зам талбай, тохижилт, инженерийн бэлтгэл арга хэмжээнд зарцуулах хөрөнгө оруулалтын урьдчилсан тойм тооцоо

| № | Хороолол | Зам талбай ($м^2$) | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) | Үерийн далан сувгийн урт (м) | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) |
|---|---|---|---|---|---|
| 1 | XIV хороолол | 188500 | 17.6 | 800 | 0.2 |
| 2 | VII хороолол | 68500 | 4.3 | 1200 | 0.5 |
| 3 | МҮОНРТ орчмын хороолол | 97600 | 6.4 | 220 | 0.08 |
| | Нийт дүн | 354600 | 28.3 | 2220 | 0.78 |

3.7.2. хоёрдугаар үе шат (2012-2015 он)

Инженерийн хангамжийн гол шугам сүлжээнд зарцуулах хөрөнгө оруулалтын урьдчилсан тойм тооцоо

| № | Хороолол | Орон сууцны тоо | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) |
|---|---|---|---|
| 1 | VII бичил хороолол (БГД. 10,11-р хороо, Хасбаатарын гудамжны хойд талд) | 9100 | 18.5 |
| 2 | Дарь-Эх хороолол (БЗД. 2-р хороо) | 2100 | 6.0 |
| 3 | Дэнжийн 1000 (ЧД. 9,10,11-р хороо) | 3600 | 14.2 |
| | Нийт дүн | 14800 | 38.7 |

Инженерийн хангамжийн эх үүсвэрийн хөрөнгө оруулалтын урьдчилсан тойм тооцоо

| № | Эх үүсвэр | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) |
|---|---|---|
| 1 | Туул 1 дүгээр коллекторыг барьж дуусгах | 10.0 |
| 2 | Төв цэвэрлэх байгууламжийн өргөтгөл | 54.0 |
| | Нийт дүн | 64.0 |

Авто тээврийн болон явган хүний зам талбай, тохижилт, инженерийн бэлтгэл арга хэмжээнд зарцуулах хөрөнгө оруулалтын урьдчилсан тойм тооцоо

| № | Хороолол | Зам талбай ($м^2$) | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) | Үерийн далан сувгийн урт (м) | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) |
|---|---|---|---|---|---|
| 1 | VII бичил хороолол | 157750 | 8.5 | 1200 | 0.5 |
| 2 | Дарь-Эх хороолол | 71000 | 4.4 | 150 | 0.06 |
| 3 | Дэнжийн 1000 | 76900 | 5.5 | 1350 | 0.7 |
| | Нийт дүн | 305650 | 18.4 | 2700 | 1.26 |

3.7.3. гуравдугаар үе шат (2016-2020 он)

-Энэ үе шатанд барих хорооллуудын орон сууцны тоо, инженерийн үндсэн шугам сүлжээнд зарцуулах хөрөнгө оруулалтын хэмжээг тухайн хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн тооцож гаргана.

Инженерийн хангамжийн эх үүсвэрийн хөрөнгө оруулалтын урьдчилсан тойм тооцоо

| № | Эх үүсвэр | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) |
|---|---|---|
| 1 | Шинээр цэвэрлэх байгууламж барих техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх | 200.0 |
| | Нийт дүн | 200.0 |

3.8. Орон сууц барих зорилтыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

3.8.1. чанартай орон сууц барина. Орон сууцны чанарыг хот байгуулалт, архитектур, барилгын хийц бүтээц, аюулгүй байдал, экологи, эрүүл ахуй, оршин суугчдын эрх ашигт нийцсэн зэрэг үзүүлэлтээр тодорхойлж түүнийг орон сууц төлөвлөх, барих үйл ажиллагааны үр дүнгийн гол хэмжүүр болгох;

3.8.2. гэрээний үндсэн дээр хувийн эзэмшлийн газраа орон сууцаар солихоор тохиролцсон иргэдийг орон сууцны барилга баригдах хугацаанд түр сууцаар хангах асуудлыг Орон сууцны санхүүжилтийн корпораци (ОССК) болон барилга барьж байгаа гүйцэтгэгч компани хариуцах;

3.8.3. Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, төсвийн ачааллыг бууруулах зорилгоор хотын захын Өлзийт, Уячдын хотхон, Гавжийн шанд, Туул тосгон зэрэг амины орон сууцны хорооллуудад иргэдийн орлогын хэмжээ, худалдан авах чадварт тохирсон амины орон сууц, түүний анхан шатны дэд бүтцийг өөрсдийн хөрөнгө болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барих ажлыг дэмжих.

3.9. Орон сууц барих зорилтыг дараах 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

3.9.1. нэгдүгээр үе шат (2008-2011 он)

-Газраа чөлөөлсөн иргэдийн түр амьдрахад зориулж 1000 айлын нийтийн орон сууц барина.

Орон сууцны тоо, хөрөнгө оруулалтын урьдчилсан тойм тооцоо

| № | Хороолол | Газар нутаг (га) | Хүн амын тоо (мян.хүн) | Орон сууцны тоо | Орон сууцанд шаардагдах хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) |
|---|---|---|---|---|---|
| 1 | XIV хороолол | 235 | 36.4 | 12000 | 272.7 |
| 2 | VII хороолол | 210 | 42.5 | 10000 | 528.1 |
| 3 | МҮОНРТ орчмын хороолол | 27 | 10.5 | 2500 | 130.5 |
| | Нийт дүн | 472 | 89.4 | 24500 | 931.3 |

3.9.2. хоёрдугаар үе шат (2012-2015 он)

-Инженерийн дэд бүтцийн бүрэн хангамжтай, амьдрах таатай орчин бүхий нийтийн орон сууцыг түлхүү барина.

Орон сууцны тоо, хөрөнгө оруулалтын урьдчилсан тойм тооцоо

| № | Хороолол | Газар нутаг (га) | Хүн амын тоо (мян.хүн) | Орон сууцны тоо (мян. орон сууц) | Орон сууцанд шаардагдах хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) |
|---|---|---|---|---|---|
| 1 | VII бичил хороолол | 93 | 40.0 | 9100 | 608.9 |
| 2 | Дарь-Эх хороолол | 61 | 8.6 | 2100 | 67.8 |
| 3 | Дэнжийн 1000 | 145 | 14.6 | 3600 | 180.8 |
| | Нийт дүн | 299.0 | 63.2 | 14800 | 857.5 |

3.9.3. гуравдугаар үе шат (2016-2020 он)

-Инженерийн дэд бүтцийн бүрэн хангамжтай, амьдрах таатай орчин бүхий амины орон сууцны хорооллыг түлхүү барина. Энэ үе шатанд барих хорооллын орон сууцны тоо, хөрөнгө оруулалтын хэмжээг тухайн хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн тооцож гаргана.

3.10. Нийгмийн дэд бүтэц байгуулах зорилтыг дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

3.10.1. нэгдүгээр үе шат (2008-2011 он)

Нийгмийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын урьдчилсан тойм тооцоо

| № | Нэрс | Сургууль | | Цэцэрлэг | | Эмнэлэг | | Бусад барилга байгууламжийн хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) | Нийт хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | (сурагч) | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) | (хүүхэд) | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) | Эмнэлэг (ор) | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) | | |
| 1 | XIV хороолол | 6000 | 7.2 | 3000 | 7.5 | 840 | 0.4 | 6.1 | 21.2 |
| 2 | VII хороолол | 8500 | 10.2 | 4250 | 10.6 | 1490 | 0.7 | 12.0 | 33.5 |
| 3 | МҮОНРТ орчмын орон сууцны хороолол | 2100 | 2.5 | 1050 | 2.6 | 370 | 0.2 | 4.4 | 9.7 |
| Нийт дүн | | 16600 | 19.9 | 8300 | 20.7 | 2700 | 1.3 | 22.5 | 64.4 |

3.10.2. хоёрдугаар үе шат (2012-2015 он)

Нийгмийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын урьдчилсан тойм тооцоо

| № | Нэрс | Сургууль | | Цэцэрлэг | | Эмнэлэг | | Бусад барилга байгууламжийн хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) | Нийт хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | (сурагч) | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) | (хүүхэд) | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) | Эмнэлэг (ор) | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) | | |
| 1 | VII бичил хороолол | 4000 | 15.8 | 6580 | 16.5 | 2300 | 1.1 | 10.0 | 43.3 |
| 2 | Дарь-Эх хороолол | 2970 | 3.6 | 2264 | 5.7 | 300 | 0.2 | 3.3 | 12.7 |
| 3 | Дэнжийн 1000 | 2910 | 3.5 | 1455 | 3.6 | 510 | 0.2 | 4.5 | 11.9 |
| Нийт дүн | | 9880 | 22.9 | 10299 | 25.8 | 3110 | 1.5 | 17.8 | 67.9 |

3.10.3. гуравдугаар үе шат (2016-2020 он)

-Энэ үе шатанд барих хорооллын нийгмийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хэмжээг тухайн хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн тооцож гаргана.

3.11. "Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр"-т шаардагдах нийт хөрөнгө оруулалтын урьдчилсан тойм тооцоо

3.11.1. нэгдүгээр үе шат (2008-2011 он)

| № | Хороолол | Газар нутаг (га) | Хүн амын тоо (мян.хүн) | Орон сууцны тоо | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Орон сууц | Нийгмийн дэд бүтэц | Инженерийн дэд бүтэц | Нийт |
| 1 | XIV хороолол | 235 | 36.4 | 12000 | 272.7 | 21.2 | 30.7 | 324.6 |
| 2 | VII хороолол | 210 | 42.5 | 10000 | 528.1 | 33.5 | 18.8 | 580.4 |
| 3 | МҮОНРТ орчмын орон сууцны хороолол | 27 | 10.5 | 2500 | 130.5 | 9.7 | 13.8 | 154.0 |
| Нийт дүн | | 472 | 89.4 | 24500 | 931.3 | 64.4 | 63.3 | 1059.0 |

3.11.2. хоёрдугаар үе шат (2012-2015 он)

| № | Хороолол | Газар нутаг (га) | Хүн амын тоо (мян.хүн) | Орон сууцны тоо | Хөрөнгө оруулалт (тэрбум төгрөг) | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Орон сууц | Нийгмийн дэд бүтэц | Инженерийн дэд бүтэц | Нийт |
| 1 | VII бичил хороолол | 93 | 40.0 | 9.1 | 608.9 | 43.3 | 25.9 | 678.1 |
| 2 | Дарь-Эх хороолол | 61 | 8.6 | 2.1 | 67.8 | 12.7 | 10.1 | 90.6 |
| 3 | Дэнжийн 1000 | 145 | 14.6 | 3.6 | 180.8 | 11.9 | 21.3 | 214.0 |
| Нийт дүн | | 299 | 63.2 | 14.8 | 857.5 | 67.9 | 57.3 | 982.7 |

3.11.3. гуравдугаар үе шат (2016-2020 он)

-Энэ үе шатанд барих орон сууцны хорооллын хөрөнгө оруулалтын нэгдсэн хэмжээг тухайн үед баригдах хорооллуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн тооцож гаргана.

3.12. Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн байгуулах зориулалтын хүрээнд хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжид заасны дагуу дараах нөхцөл, шаардлагыг заавал хангасан байна:

3.12.1. гудамж, замын сүлжээг тээврийн хэрэгсэл, дугуйтай болон явган зорчигчийн хөдөлгөөн, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, орон зайн зохиомж, орчны барилга байгууламжийн байршил, уран барилгатай нь уялдуулан, тасралтгүй өсөн хөгжих хөдөлгөөнтэй нэгдсэн систем байх;

3.12.2. төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн 30-аас доошгүй хувь нь цэцэрлэг, ногоон байгууламж, автомашины зогсоол байх.

**Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

4.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд Засгийн газрын 2008 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх арга хэмжээг удирдан зохицуулах" үүрэг бүхий ажлын хэсэг хариуцна.

4.2. Хөтөлбөрийн санхүүжилтийн асуудлыг удирдан зохион байгуулах үйл ажиллагааг Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулна.

4.3. Нийслэл, дүүрэг, хороодын Засаг дарга, тухайн орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

4.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагааг тухайн хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, иргэд, олон нийтийн оролцоог зохицуулах үүрэг бүхий төслийн нэгжүүд зохион байгуулна;

4.5. Олон нийтэд хөтөлбөрийн ач холбогдлыг сурталчлах ажлыг идэвхжүүлэх, иргэдийн үүсгэл санаачилгыг өрнүүлэх, санал солилцох уулзалтуудыг тогтмол зохион байгуулах ажлыг "Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх арга хэмжээг удирдан зохицуулах" үүрэг бүхий ажлын хэсэг, нийслэл, дүүрэг, хороодын Засаг дарга, төслийн нэгжүүд хамтран зохион байгуулна.

**Тав. Хөтөлбөрийн санхүүжилт**

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1. улсын болон орон нутгийн төсвөөс гэр хорооллын ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц барихад хуваарилсан хөрөнгө;

5.1.2. Засгийн газрын бонд болон ипотекээр баталгаажсан үнэт цаасны борлуулалтын орлогын эх үүсвэр;

5.1.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт бүхий аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө оруулалт;

5.1.4. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан зориулалтын хөрөнгө;

5.1.5. газрыг эдийн засгийн эргэлтэд оруулснаас бий болсон хөрөнгө;

5.1.6. бусад.

5.2. Төсвийн ачааллыг бууруулах зорилгоор иргэдийн орлогын хэмжээ, худалдан авах чадварт тохирсон нийтийн болон амины орон сууц, түүний дэд бүтцийг хувийн хэвшил болон иргэд өөрсдийн хөрөнгөөр барих ажлыг дэмжинэ.

**Зургаа. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт**

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

6.1.1. Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх хангагдах нөхцөл бүрдэнэ;

6.1.2. гэр хорооллыг дахин төлөвлөж орон сууцны хороолол болгон хөгжүүлэх замаар 2020 он гэхэд Улаанбаатар хотын хүн амын 82 хувийг инженерийн хангамжтай тохилог орон сууцаар хангасан байна;

6.1.3. Улаанбаатар хотын агаар, хөрс, усны бохирдол эрс багассан байна;

6.1.4. Улаанбаатар хотын хэмжээнд нягтрал сайтай, инженерийн болон нийгмийн дэд бүтцийн бүрэн хангамжтай өндөр ашиг бүхий газар нутгийн хэмжээ нэмэгдсэн байна;

6.1.5. ажлын байр шинээр бий болж, иргэдийн тодорхой хэсэг орлогын тогтмол эх үүсвэртэй болсон байна.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

6.2.1. ашиглалтад орсон хороолол, орон сууцны тоо;

6.2.2. агаар, хөрс, усны бохирдлын хэмжээ буурсан үзүүлэлт;

6.2.3. инженерийн болон нийгмийн дэд бүтцийн бүрэн хангамжтай газрын хэмжээ;

6.2.4. шинээр бий болсон ажлын байрны тоо.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 07 дугаар сарын 29-ний өдөр** **Дугаар 304** **Улаанбаатар хот**

**Дүрэм батлах тухай**

Нийгмийн даатгалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм"-ийг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 1994 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 171 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Д.ДЭМБЭРЭЛ**

Засгийн газрын 2008 оны 304 дүгээр тогтоолын хавсралт

## ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ КОМИССЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс (цаашид "комисс" гэх)-ын зорилго нь ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас (хэсэгчлэн) алдсан шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээ, хугацаа болон хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх асуудлыг магадлан шийдвэрлэхэд оршино.

1.2. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэд эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дэргэд эмнэлэг хөдөлмөрийн магадлах орон нутгийн комисс ажиллана.

1.3. Хүн амын нягтрал, аж ахуйн нэгж, байгууллагын төвлөрөл, эмнэлгийн тусламж, үйлчилгээний материаллаг бааз, нарийн мэргэжлийн эмч нарын хангамж зэрэгтэй уялдуулан суманд эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс байгуулан ажиллуулж болно.

1.4. Комисс нь үйл ажиллагаандаа Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан заавар, журам болон энэхүү дүрмийг мөрдлөг болгоно.

1.5. Комисс нь тогтоосон журмын дагуу хийсэн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.6. Комисс нь эрх хэмжээнийхээ асуудлаар шийдвэр гаргах бөгөөд түүнийг даатгалын харилцаанд оролцогч талууд биелүүлэх үүрэгтэй.

Хоёр. Комиссын бүрэлдэхүүн

2.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс нь 11 хүний бүрэлдэхүүнтэй байна. Комиссын бүрэлдэхүүнийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно. Төв комисс нь орон нутгийн комиссыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, эмнэлэг хөдөлмөрийн магадлагааны талаар гарсан маргааныг хянан шийдвэрлэнэ.

Төв комиссын дарга, нарийн бичгийн дарга, магадлагч эмч орон тооны байна.

2.2. Аймаг, дүүргийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь нарийн мэргэжлийн дотрын, мэдрэлийн, мэс заслын эмч, нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч, нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч эмч, нарийн бичгийн дарга болон нийгмийн халамжийн байгууллага, ажил олгогч, даатгуулагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах байгууллагуудын төлөөлөл бүхий 9-11 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.3. Аймаг, дүүргийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын бүрэлдэхүүнийг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга тухайн шатны Засаг дарга болон эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын даргатай зөвшилцсөний үндсэн дээр томилно.

2.4. Суманд эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс байгуулах бол түүний бүрэлдэхүүнийг аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга аймгийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дарга болон тухайн сумын Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр томилно.

2.5. Аймаг, дүүрэг, сумын эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нь орон тооны бус байна.

Гурав. Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, түүний хувь хэмжээ, хугацааг тогтоох

3.1. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгааныг ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын улмаас гэж ангилна.

3.2. Хөдөлмөрийн чадвар алдаж хөгжлийн бэрхшээлтэй болсныг хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу 70-аас дээш хувь, хагас (хэсэгчлэн) буюу 50-69 хувиар алдсан гэж ангилан тогтооно.

3.3. Даатгуулагчийн хөгжлийн бэрхшээлтэй болсныг тогтоохдоо Нийгмийн даатгалын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг үндэслэн энэ дүрмийн 3.1-д заасан шалтгаан тус бүрээр тогтооно.

3.4. Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан бол хөдөлмөрийн чадвар алдсан байдалд байгаа хугацааг эхний удаад 3-24 сараар, хөдөлмөрийн чадвараа хагас алдсан бол 3-12 сараар тус тус тогтооно.

3.5. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар нь нөхөн сэргээгдэх хүртэл энэхүү дүрмийн 3.4-т заасан хугацаанд хөдөлмөрийн чадвар алдсан хугацааг сунгаж болно.

3.6. Харин даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээгдэхгүй нь тогтоогдвол түүний хөгжлийн бэрхшээлтэй болсныг хугацаагүйгээр тогтоож болно.

Дөрөв. Комиссын эрх, үүрэг

4.1. Комисс нь дараах эрх эдэлнэ:

4.1.1 комиссын шийдвэрийг ажил олгогч, даатгуулагч хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

4.1.2 хүндэтгэх шалтгаангүйгээр эмнэлэг хөдөлмөрийн магадлалд ороогүй даатгуулагчид дахин магадлагаа явуулахаас татгалзах;

4.1.3 комиссын ажилд нарийн мэргэжлийн эмч нарыг оролцуулах, эмнэлгийн байр, багаж хэрэгслийг үнэ төлбөргүйгээр түр ашиглах;

4.1.4 хүндэтгэн үзэх шалтгаанаар эмнэлэг хөдөлмөрийн магадлагаа тогтоолгож чадаагүй даатгуулагчийн хөгжлийн бэрхшээлтэй болсныг нөхөн тогтоох;

4.1.5 төв комисс нь аймаг, дүүрэг, сумын комиссоос гаргасан шийдвэр буруу байвал түүнийг өөрчлөх, хүчингүй болгох, эмнэлэг хөдөлмөрийн магадлагаа хийх үйл ажиллагаанд алдаа, дутагдал гаргасан, төрийн албан хаагчийн болон эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн комиссын дарга, гишүүнд захиргааны хариуцлага хүлээлгэх, өөрчлөх талаар холбогдох албан тушаалтанд санал тавих.

4.2 Комисс дараах үүрэг гүйцэтгэнэ:

4.2.1. төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ болон эмнэлгийн ажилтны ёс зүйн дүрмийг чанд сахин биелүүлэх;

4.2.2. ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ тогтоох, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх шийдвэр гаргах;

4.2.3. хөдөлмөрийн нөхцөл нь биеийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж, тухайн өвчин эмгэг нь даамжран цаашид хүндрэх төлөвтэй даатгуулагчийн хөдөлмөрийн нөхцөлийг эхний удаа 6 сар хүртэл хугацаагаар өөрчлөх, шаардлагатай бол уг нөхцөлийг бүрэн өөрчлөхөөр шийдвэрлэх;

4.2.4. биеийн эрүүл мэндийн байдал нь хүндэрч, хөдөлмөрийн чадвар алдалт нь цаашид даамжрах төлөвтэй, дадаж мэргэшсэн ажлаа хөдөлмөрийн тогтоосон цагт тоо чанарын хувьд бүрэн хийж чадахгүй болсон даатгуулагчид сувилуулах, эмчлүүлэхэд нь зориулж ажлын цагийг хорогдуулах талаар шийдвэр гаргах;

4.2.5. иргэнийг бүрэн хараагүй, хэлгүй, дүлий болон одой болохыг тогтоох;

4.2.6. 16 насанд хүрснээс хойш хөгжлийн бэрхшээлтэй болсныг тогтоох;

4.2.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэн өөрт тохирсон мэргэжил эзэмших, хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжоор хангагдах талаар дэмжлэг үзүүлж ажиллах;

4.2.8. төв комисс нь эмнэлэг хөдөлмөрийн магадлалын ажлын тайлан, мэдээг улсын хэмжээгээр хагас, бүтэн жилээр нэгтгэн дүгнэлтээ нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

4.2.9. төв комисс нь ажлаа нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд жил бүр тайлагнах.

Тав. Комиссын ажиллах журам

5.1. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь хэмжээ тогтоох, хугацааг сунгах, цуцлах, хөдөлмөр зохицуулалт хийх асуудлыг эмнэлгийн байгууллагын эмчилгээний чанарын хяналтын комиссын шийдвэрийг үндэслэн комисс тогтооно.

5.2. Комисс нь долоо хоногт нэг удаа хуралдана. Комиссын хурлыг гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон нөхцөлд хийнэ.

5.3. Комисс нь аймгаас алслагдсан суманд нүүдлийн хурал хийж болно.

5.4. Комисс нь эмнэлэг хөдөлмөрийн магадлалыг явуулахдаа даатгуулагчийн асуудлыг өвчний оношийн үндэслэлийг нягтлан, ялган оношлолт хийж, эмчлэгч эмч болон эмнэлгийн эмчилгээний чанарын хяналтын комиссын саналыг харгалзан гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

5.5. Орон нутгийн комиссын шийдвэрийг зөвшөөрөөгүй даатгуулагч нь дээд шатны комисст гомдлоо гаргаж болно. Тухайн комисс даатгуулагчийн гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шалгаж барагдуулна. Дээд шатны комиссын шийдвэрийг зөвшөөрөөгүй даатгуулагч гомдлоо шүүхэд гаргаж болно.

5.6. Төв комисс нь даатгуулагчийн гомдлыг барагдуулахдаа асуудлыг төв комиссын гишүүдийн хурлаар дахин магадлал хийх, эсхүл эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөлийн дарга болон ерөнхий мэргэжилтэн, зөвлөлийн гишүүн-нарийн мэргэжлийн эмчийн дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

5.7. Комисс нь бүртгэл, мэдээллээр хяналт тавих, судалгаа, нэгдсэн дүгнэлт гаргахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаархи мэдээллийн санг ашиглана.

5.8. Комиссын шийдвэрт комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж, тэмдэг дарна.

5.9. Орон нутгийн комисс нь үйл ажиллагааныхаа тайланг төв комисст ирүүлнэ.

5.10. Комиссын дарга, гишүүдэд зохих урамшуулал олгох бөгөөд түүний хэмжээг нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

5.11. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусгах арга хэмжээг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар зохион байгуулна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 08 дугаар сарын 27-ны өдөр** | **Дугаар 331** | **Улаанбаатар хот**

**Ажилд томилох тухай**

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Дамдины Цогтбаатарыг Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2008 оны 08 дугаар сарын 27-ны өдөр** | **Дугаар 332** | **Улаанбаатар хот**

**Ажилд томилох тухай**

Засгийн газрын тухай хуулийн $18^3$ дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Содномын Энхбатыг Цөмийн энергийн комисс-Засгийн газрын тохируулагч агентлагийн даргаар томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>>** эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 265958
Индекс 14003
Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв
☎ 329487
Хэвлэлийн хуудас 3